

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдалд хийсэн үнэлэлт, дүгнэлт – 2023 он

2023.04.21

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан үндсэн чиг үүрэг, бүрэн эрхийн дагуу өргөн нэвтрүүлгийн салбарт төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хүрээнд эрх зүйн оновчтой зохицуулалтаар хангаж, нийтийн ашиг сонирхолд нийцсэн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг хэрэгжүүлж ажилладаг.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөл байдлыг бүрдүүлж, жил бүр үнэлэлт, дүгнэлт гаргаж ажиллах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчилсан. Иймээс өргөн нэвтрүүлгийн бодлого, зохицуулалтын болон өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаанд зайлшгүй баримтлах зарчмуудыг хуулийн 5 дугаар зүйлээр заасан байх ба 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9-д “... зах зээлийн өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлж, өргөн нэвтрүүлгийн салбарын хөгжлийг дэмжин хөгжүүлэх” зарчмыг баримтлахаар заасан билээ.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10-т заасныг үндэслэн хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж, дүрэм журам, нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангуулах замаар өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээтэй холбоотой онцлог зохицуулалтыг хэрэгжүүлж, өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах, шударга өрсөлдөх нөхцөлийг бий болгох, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасны дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн талаарх мэдээллийг ил тод байлгаж, 19.5-д зааснаар жил бүр олон нийтэд мэдээлж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь дээр чиг үүрэг, зорилгын дагуу хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотой үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг тогтмол авч ажиллаж байгаа бөгөөд зах зээл, хүн ам, эрэлт хэрэгцээ, эзэмшил, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгаанд үндэслэн өрсөлдөх нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, тусгай зөвшөөрлийн тоо тогтоох, олгох эсэх шийдвэрийг судалгаа, үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн гаргаж байна.

Тус хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт гаргахад дараах үндсэн чиглэлийг

авч үзсэн бөгөөд эдгээр чиглэлийн хүрээнд хийсэн судалгаа, мэдээлэлд үндэслэн үнэлэлт, дүгнэлт гаргасан болно. Үүнд:

- I. Өргөн нэвтрүүлгийн хууль эрх зүйн орчин, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлэлт, дүгнэлт, хэрэгжилтийн хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
- II. Тайлант хугацаанд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх хуульд заасан тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тоо, мэдээ;
- III. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эзэмшлийн талаарх мэдээллийг ил тод байлгах зохицуулалт, хэрэгжилтийн нөхцөл байдал, үнэлэлт, дүгнэлт;
- IV. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээл, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаа, үнэлэлт, дүгнэлт;
- V. Тус хорооноос 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтооход баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлт, шийдвэр.

I. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Нэг. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы хуралдаанаар Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 35 тоот тогтоолд зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, шийдвэрийг Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Монгол Улсын Их Хурлаас Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2023 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр баталсан.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дэх хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасныг үндэслэн тус Хорооны 2020 оны 64 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-ыг тус хорооны 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 02 тоот тогтоолоор хүчингүй болгосон. Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулсан нөхцөл, шаардлага, дүрэм, журам, баримт бичигт үзлэг хийж, шаардлагатай захиргааны хэм хэмжээний актуудыг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 4 баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж тус Хорооны 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн (1, 14, 15, 16-р тогтоол) баталж, ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн.



Тус Хорооны даргын 2020 оны 62 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан "Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам"-ын хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг тус Хорооны 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн (43-р тогтоол) баталж, ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн.

Эрх бүхий байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирсэн санал, хүсэлт, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын дагуу тус Хорооны 2021 оны 1 тоот тогтоолоор баталсан "Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага", 2020 оны 89 тоот тогтоолоор баталсан "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам"-ын холбогдох заалтуудын хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг тус хорооны 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр (59-р тогтоол), 12 дугаар сарын 22-ны өдрийн (60-р тогтоол) ээлжит хуралдаанаар хэлэлцэн баталж, ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн.

Хоёр. Тус хорооноос хийж, гүйцэтгэсэн хяналт, шалгалтын талаар

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн албан хүсэлт, гомдлын дагуу хэмжилт, хяналт, шалгалтыг хийж, хуулийн дагуу арга хэмжээг авч, илэрсэн зөрчлийг арилгуулах ажлын хүрээнд тус Хорооны даргын 2022 оны А/69 тоот тушаал, удирдамжийн дагуу Баянхонгор, Өвөрхангай аймагт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг 2022 оны 03 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд, тус хорооны даргын 2022 оны А/119 тоот тушаал, удирдамжийн дагуу Говьсүмбэр, Сүхбаатар, Дорнод аймагт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2022 оны 04 дүгээр сарын 19-25-ны өдрүүдэд тус тус хийж гүйцэтгэж холбогдох арга хэмжээг авч ажилласан. Тус хорооны даргын А/69 тоот шалгалтын дүнгээр 4 телевизэд хугацаатай үүрэг даалгавар өгч, үйл ажиллагаа эхлүүлээгүй 1 телевизэд мэдэгдэл хүргүүлж, тус тус хүчингүй болгож, 3 телевиз, 1 радио, 2 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид зөвлөмж хүргүүлж ажилласан. Тус хорооны даргын А/119 тоот шалгалтын дүнгээр 1 телевизэд хугацаатай үүрэг даалгавар өгч, хүчингүй болгож, 5 телевиз, 1 радио, 1 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид зөвлөмж хүргүүлсэн. Дорноговь аймгийн Иххэт сум, Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-Уул суманд радио давтамжийн нөлөөллийг илрүүлэх, арилгах хэмжилт хийж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Бүсийн төлөвлөгөөт хяналт, шалгалтын хүрээнд тус хорооны даргын 2022 оны А/189 тоот тушаал, удирдамжийн дагуу Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд, Говь-Алтай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа өргөн нэвтрүүлгийн 18 үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн гэрээний үүрэг, нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд газар дээр нь үзлэг, шалгалт хийх төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2022 оны 6 дугаар сарын 17-с 7 дугаар сарын 04-ний өдрийн хооронд хийж, өргөн нэвтрүүлгийн хууль тогтоомж, зохицуулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч, сургалт зохион байгуулж ажилласан. Бүсийн шалгалтын дүнгээр 5 телевиз, 1 радиод хугацаатай үүрэг даалгавар, 2 телевизэд үйл ажиллагаа эхлүүлэх тухай албан шаардлага тус тус хүргүүлж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Улаанбаатар хотын телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд хяналт, шалгалт хийх ажлын хүрээнд тус хорооны даргын 2022 оны А/254 тоот тушаал, удирдамжийн дагуу Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол

Улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй өргөн нэвтрүүлгийн 18 телевиз болон арилжааны 30 телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт, шалгалтыг 2022 оны 09 дугаар сарын 30-с 10 дугаар сарын 24-ний өдрийн хооронд хийж ажилласан. Төлөвлөгөөт шалгалтын дүнгээр арилжааны 6 телевизэд шалгалтын дүн, арилжааны 8, өргөн нэвтрүүлгийн 18 телевизэд хугацаатай үүрэг даалгавар, арилжааны 5 телевизэд мэдэгдэл тус тус хүргүүлж, 6 арилжааны телевизийн тусгай зөвшөөрлийг 2022 оны 71 тоот тогтоолоор түдгэлзүүлэх арга хэмжээ зэрэг холбогдох арга хэмжээг авсан.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд хяналт, шалгалт хийх ажлын хүрээнд тус хорооны даргын 2022 оны А/318 тоот тушаал, удирдамжийн дагуу Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй 13 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд 2022 оны 12 дугаар сарын 01-20-ны өдрийн хооронд хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулан ажилласан. Шалгалтын дүнгээр 3 үйлчилгээ эрхлэгчид хугацаатай үүрэг даалгавар, 1 үйлчилгээ эрхлэгчид албан шаардлага, 8 үйлчилгээ эрхлэгчид заавар, зөвлөмж тус тус хүргүүлж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.. Үйл ажиллагаа эхлүүлээгүй 1 этгээдэд үйл ажиллагаа эхлүүлэх тухай мэдэгдэл хүргүүлсэн.

Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгчдэд хяналт, шалгалт хийх ажлын хүрээнд тус хорооны даргын 2023 оны А/46 тоот тушаал, удирдамжийн дагуу радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 2 үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт, шалгалт хийж, шалгалтын хүрээнд үйлчилгээ эрхлэгчийн хүсэлтийг үндэслэн 1 үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээ эрхлэх, радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон.

Тус хорооны даргын 2023 оны А/47 тоот тушаал, удирдамжийн хүрээнд Төв, Дундговь, Өмнөговь аймагт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт, шалгалтыг 2023 оны 03 дугаар сарын 13-17-ны өдрүүдэд хяналт, шалгалт хийж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 4 үйлчилгээ эрхлэгчид хугацаатай үүрэг даалгавар, 5 үйлчилгээ эрхлэгчид заавар зөвлөмж хүргүүлсэн. Шалгалтын үеэр холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар бүх үйлчилгээ эрхлэгчдийг хамруулан сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Тус хорооны даргын 2023 оны А/254 тоот тушаал, удирдамжийн хүрээнд хийсэн шалгалтын дүнгээр хугацаатай үүрэг даалгавар өгөгдсөн, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд тус хорооны даргын 2023 оны А/52 тоот тушаал, удирдамжийн дагуу гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг 2023 оны 3 дугаар сарын 3-7-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн. Шалгалтын дүнг нэгтгэж, тайлан, авах арга хэмжээний саналыг 2-р улиралд танилцуулахаар бэлтгэж байна.

Гурав. Тус хорооноос хийгдэж байгаа хяналт, мониторингийн талаар

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс үйлчилгээний тасралтгүй ажиллагааны тайлан (ТАТ) тогтмол хүлээн авч, үйлчилгээний хэвийн тасралтгүй ажиллагааг хангуулах чиглэлээр телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн эфирийн ТАТ тайланг тус хорооноос хийгддэг байнгын хяналт мониторингийн хүрээнд болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид, телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс тус тус хүлээн авч нэгтгэн, анализ хийж байгууллагын цахим хуудсанд байршуулж ажиллаж байна. (<https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=254>). Үйлчилгээ нь тасарсан үйлчилгээ эрхлэгчдээс эфир

тасарсан шалтгааныг тодруулж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авч ажилласан.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.8-д заасан эрх, чиг үүргийн хүрээнд “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”, “Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Радиоогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам” батлан гаргаж, хэрэгжилтэд хяналт, мониторинг хийж ажиллаж байна.

1.Телевизийн хөтөлбөрт хийгддэг байнгын хяналт, мониторингийн хүрээнд:

- Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа бүх телевизүүд (үүнд: Монголын үндэсний олон нийтийн 5 телевиз, өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, арилжааны 61 телевиз) хамрагдаж байна.
- Орон нутагт тусгай зөвшөөрөлтэй нийт 62 телевизийн хөтөлбөрт түүврийн аргаар буюу сард 15 телевизийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийж байна.

2.Радиоогийн хөтөлбөрт хийгддэг байнгын хяналт, мониторингийн хүрээнд:

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй радиоогийн үйлчилгээ эрхлэгчдийн (Монголын үндэсний олон нийтийн 4 радио, 33 радио) хөтөлбөрт түүврийн аргаар буюу сар бүр 10 радиоогийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио, телевизүүдийн хөтөлбөрт хийсэн хяналт, мониторингийн дүнг телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд тогтмол хүргүүлэх, холбогдох арга хэмжээ авах, хяналт, мониторингийн дүн, мэдээг олон нийтэд ил тод мэдээлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос хийдэг телевизийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүн, мэдээллийн дэлгэрэнгүйг тус хорооны <https://www.crc.gov.mn/list/rq-n-nevtr-leg/mn?show=27> хуудаснаас он тус бүрээр дэлгэрүүлэн үзэх боломжтой ба радиоогийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүн, мэдээллийн дэлгэрэнгүйг <https://www.crc.gov.mn/list/rq-n-nevtr-leg/mn?show=251> хуудаснаас татан авч, танилцана уу.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжуулж байгаа гадаад улсын сувгийг бүртгэх ажлыг Харилцаа холбооны зохицуулах хороо, Оюуны Өмчийн Газрын даргын 2021 оны 2-р сарын 5-ны өдрийн хамтарсан А/26 - А/13 тоот тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу хүлээн авч, бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй 32 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчээс 2021 онд гадаад сувгийн бүртгэл, мэдээлэл ирүүлсэн 21 үйлчилгээ эрхлэгчийн мэдээллийг хянаж, бүртгэл хөтөлж ажилласан бөгөөд гадаад сувгийн бүртгэлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.crc.gov.mn/list/rq-n-nevtr-leg/mn?show=28> хуудаснаас танилцана уу.

Дөрөв. Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2022 оны А/86 тоот тушаалын хавсралтаар хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн



радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн ажиллах дотоод журам, зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, зөвлөлийн хуралдааныг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна. Зөвлөлөөс гарсан хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан зөвлөмжийг зөрчил гаргасан Улаанбаатар хотын 1 радио, 1 арилжааны телевизэд, зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаас гарсан нийтлэг зөвлөмжийг тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад тус тус хүргүүлж, хорооны цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлсэн (<https://www.crc.gov.mn/articles/mn>).

II. ТАЙЛАНТ ХУГАЦААНД ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН, СУНГАСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН, СЭРГЭЭСЭН, ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТОО, МЭДЭЭ

Харилцаа холбооны зохицуулах хорооноос **2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн** хооронд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6.1.6-д заасан төрөлд тусгай зөвшөөрөл олгох, мөн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, дуусгавар болох үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу дараах байдлаар хэрэгжүүлж ажилласан.

Нэг. Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо тогтоосон байдал¹, сонгон шалгаруулалтын дүн:

Д/д	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тайлант хугацаанд зохион байгуулсан сонгон шалгаруулалтын тоо, нэр	ҮҮНЭЭС		Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрлийн эзэмшигчдийн нийт тоо
			олгогдсон	татгалзсан	
1	Арилжааны радио	3 ²	2 ³	-	59

Хоёр: Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6.1.6-д заасан төрөлд тусгай зөвшөөрөл олгох хүсэлт шийдвэрлэсэн байдал:

Д/д	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тайлант хугацаанд ирсэн тусгай зөвшөөрлийн хүсэлтийн тоо, нэр	ҮҮНЭЭС		Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрлийн эзэмшигчдийн нийт тоо
			олгогдсон	татгалзсан	
1	Төлбөртэй телевиз	14 ⁴	9 ⁵	5 ⁶	17

¹ Тус хорооны 2021 оны 71 тоот тогтоолоор нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо батлагдсан.

² Архангай, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад

³ Архангай аймагт – Ар Би Эм Ти ХХК, Хөвсгөл аймагт – Хасүби медиа ХХК-д тусгай зөвшөөрөл олгосон. Сэлэнгэ аймагт оролцох санал ирээгүй.

⁴ Монвсат нэтворк ХХК, Туургатан медиа групп ХХК, Маст технологи ХХК, Скайтел ХХК

⁵ Монвсат нэтворк ХХК-д 5, Маст технологи ХХК-д 3 (2023 оны 5-р тогтоол), Скайтел ХХК-д 1 (2023 оны 31-р тогтоол) тусгай зөвшөөрөл тус тус олгосон.

⁶ Монвсат нэтворк ХХК-н 1, Туургатан медиа групп ХХК-н 4 хүсэлтэд татгалзсан.

Гурав: Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн арга хэмжээний талаар:

Д/д	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тайлант хугацаанд түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрлийн тоо, нэр	ҮҮНЭЭС			Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрлийн эзэмшигчдийн нийт тоо
			сэргээгдсэн	хүчингүй болсон	түдгэлзүүлсэн хугацаа дуусаагүй	
1	Өргөн нэвтрүүлгийн телевиз – Орон нутаг	14	3 ⁷	10 ⁸	1 ⁹	47
2	Арилжааны телевиз – УБ хот	12	7 ¹⁰	1 ¹¹	4 ¹²	55
3	Арилжааны радио – Орон нутаг	1			1 ¹³	26
4	Арилжааны радио – УБ хот	1			1 ¹⁴	33
Нийт		28	10	11	7	

Дөрөв. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байдал:

Д/д	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тайлант хугацаанд сунгалт хийх хүсэлт ирүүлсэн тусгай зөвшөөрлийн тоо, нэр	ҮҮНЭЭС		Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрлийн эзэмшигчдийн нийт тоо
			сунгасан	татгалзсан	
1	Олон нийтийн телевиз	1	1		5
2	Төлбөртэй телевиз	1	1		17
3	Өргөн нэвтрүүлгийн телевиз – УБ хот	7	7		18
4	Өргөн нэвтрүүлгийн телевиз – Орон нутаг	18	18		47

⁷ 2023 оны 6-р тогтоолоор сэргээсэн – Ди медиа агентлаг ХХК, Завхан толь сонин ХМХ, Гэгээн гэгээ ХХК

⁸ 2023 оны 13-р тогтоолоор хүчингүй болсон – Баянхонгор хөгжлийн ертөнц телевиз ХХК, Ситиблессинг ХХК, Гэгээн соёмбо ХХК, Дөлгөөн соёмбо ХХК, Буган соёл ХХК, Хийморилор эрчүүдийн хүч ХХК, Үзэсгэлэнт мөрөн ХХК; тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан – Ханлиг тайшир ХХК, Төгөлдөр-Өв ХХК, Буянт чандмань социал медиа ХХК

⁹ 2023 оны 28-р тогтоолоор түдгэлзүүлсэн – Хувь хүний хөгжлийн баруун бүсийн институт НҮТББ

¹⁰ 2023 оны 26-р тогтоолоор сэргээсэн – Малчин телевиз ХХК, Эгон ХХК, Эх гоёот медиа групп ХХК, Монзах ХХК, Форчун глобал ХХК, Монвсат нэтворк ХХК, Эс Си Эйч ХХК

¹¹ 2022 оны 52-р тогтоолоор хүчингүй болсон – Би энд би пикчерс ХХК

¹² 2022 оны 71-р тогтоолоор түдгэлзүүлсэн - Эм Ви Эс ХХК, Эн Би Жи Кинг Монголиа ХХК, 2023 оны 28-р тогтоолоор түдгэлзүүлсэн –Эм жи эл медиа групп ХХК, Байсикл медиа ХХК

¹³ 2023 оны 28-р тогтоолоор түдгэлзүүлсэн – Топ дэвшил ХХК

¹⁴ 2023 оны 28-р тогтоолоор түдгэлзүүлсэн – Монкаст радио ХХК

5	Арилжааны телевиз – УБ хот	26	23	3 ¹⁵	55
6	Арилжааны телевиз – Орон нутаг	2	2		3
7	Олон суваг дамжуулах үйлчилгээ	4	4		30
8	Арилжааны радио	27	26	1 ¹⁶	59
Нийт		86	82	4	

Тав. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байдал:

Д/д	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тайлант хугацаанд хүчингүй болсон тусгай зөвшөөрлийн тоо, нэр	Үндэслэл	Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрлийн эзэмшигчдийн нийт тоо
1	Өргөн нэвтрүүлгийн телевиз – Орон нутаг	13	Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2-р зүйлийн 1.1 ¹⁷ – 3 Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2-р зүйлийн 1.2 ¹⁸ – 7 Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1.1 ¹⁹ – 3	47
2	Арилжааны телевиз – УБ хот	7	Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2-р зүйлийн 1.8 ²⁰ – 1 Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2-р зүйлийн 1.2 ²¹ – 1 Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.5 ²² – 3 Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1.1 ²³ – 2	55
3	Олон суваг дамжуулах үйлчилгээ – Орон нутаг	4	Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2-р зүйлийн 1.1 ²⁴ – 3	30

¹⁵ Дөрөв кэй ХХК, Монгол масс медиа ХХК, Орчил ивэг ХХК - Харилцаа холбооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4

¹⁶ Дархан комфорт цогцолбор ХХК-ийн сунгах дүгнэлт гарсан ч өөрийн хүсэлтээр сунгуулахаас татгалзсан

¹⁷ Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2.1.1. зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан – Уян утсан сүлжээ ХХК, Эко жаргалант ХХК, МДЛО ХХК;

¹⁸ Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2.1.2. зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй – Баянхонгор хөгжлийн ертөнц телевиз ХХК, Ситиблессинг ХХК, Гэгээн соёмбо ХХК, Дөлгөөн соёмбо ХХК, Буган соёл ХХК, Хийморилог эрчүүдийн хүч ХХК, Үзэсгэлэнт мөрөн ХХК;

¹⁹ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17.1.1. тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан – Ханлиг тайшир ХХК, Төгөлдөр-Өв ХХК, Буянт чандмань сошиал медиа ХХК;

²⁰ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17.1.1. тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан - Одод ти ви ХХК;

²¹ Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2.1.2. зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй - Би энд би пикчерс ХХК;

²² Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 13.5. Зохицуулах хороо Харилцаа холбооны тухай хуулийн 14.11-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзана – Дөрөв кэй ХХК, Монгол масс медиа ХХК, Орчил ивэг ХХК;

²³ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17.1.1. тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан – Випмедиа групп ХХК, Оргил медиа консалтинг ХХК;

²⁴ Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2.1.1. зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан - Нью Наз ХХК, Гантиг гурван сэнхэр ХХК, Болор утас ХХК;

			Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1.1 ²⁵ – 1	
4	Арилжааны радио	3	Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2-р зүйлийн 1.1 ²⁶ – 1, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1.1 ²⁷ – 2	59
5	Төлбөртэй телевиз	3	Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2-р зүйлийн 1.1 ²⁸ – 3	17
Нийт		30	30	

Зургаа. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал:

Д/д	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тайлант хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулсан тусгай зөвшөөрлийн тоо, нэр	ҮҮНЭЭС		Үйлчилгээний нэр өөрчилсөн	Бусад өөрчлөлт	Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрлийн эзэмшигчдийн нийт тоо
			тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн, хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдсөн	үйлчилгээ эрхлэх хүрээ, байршил өөрчлөгдсөн			
1	Өргөн нэвтрүүлгийн телевиз – УБ хот	1	1 ²⁹				18
2	Өргөн нэвтрүүлгийн телевиз – Орон нутаг					4 ³⁰	47
3	Арилжааны телевиз – УБ хот	5	5 ³¹ 32 33 34 35	1 ³⁶	1 ³⁷		55

²⁵ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17.1.1. тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан – Скайка ти ви ХХК;

²⁶ Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2.1.1. зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан – Сайхан Монгол ЭИАК НҮТББ²⁶, Аавын ерөөл ТББ²⁶, Дархан комфорт цогцолбор ХХК²⁶)-ны 2023 оны 11-р тогтоолоор хүчингүй болсон

²⁷ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17.1.1. тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан – Аавын ерөөл ТББ Дархан комфорт цогцолбор ХХК;

²⁸ Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2.1.1. зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан – Контент дистрибушн ХХК-ийн нэр дээрх 3 телевиз (2023 оны 21-р тогтоол);

²⁹ 2022 оны 50-р тогтоол тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай – Эм Би Эс ХХК-с Чаннел-Уан ХХК

³⁰ Бунадо ХХК, Номин Макс ХХК, Буян налайх ХХК-ийн хувьцаа эзэмшилд өөрчлөлт орсон. Хөвсгөл мэдээллийн төв НҮТББ-ын удирдах зөвлөлд өөрчлөлт орсон

³¹ 2022 оны 29-р тогтоол тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай – Лидер медиа групп ХХК-с Төгс барчин хангай ХХК

³² 2022 оны 14-р тогтоол тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай – Спаркс индастри ХХК-с Трионикс метавишн ХХК

³³ 2022 оны 23-р тогтоол тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай – Волюм плас ХХК-с Монгол телевиз ХХК

³⁴ 2023 оны 7-р тогтоол тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай - Трейд телевиз ХХК-ийн хуулийн этгээдийн оноосон нэрийг Хөгжил телевиз ХХК болгож өөрчилсөн

³⁵ 2023 оны 33-р тогтоол тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай – Натурхаан медиа ХХК-ийн хуулийн этгээдийн оноосон нэрийг Лакс ТВ Монгол ХХК болгож өөрчилсөн

³⁶ 2022 оны 40-р тогтоол тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай – Парламентийн суваг ХХК хамрах хүрээг МУ-ын нутаг дэвсгэрт болгон өөрчлөлт оруулсан

³⁷ Шууд ти ви ХХК-с үйлчилгээний нэрийг ШуудТВ-с Асаршоп болгосон

4	Арилжааны телевиз – Орон нутаг				1 ³⁸	3
5	Олон суваг дамжуулах үйлчилгээ – Орон нутаг	1		1 ³⁹		30
6	Арилжааны радио	2	2 ⁴⁰ 41		1 ⁴²	59
	Нийт	9	8	2	2	5

III. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙЛГАХ ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасны дагуу өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгахаар зохицуулсан. Харилцаа холбооны зохицуулах хорооноос уг хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.5, 30 дугаар зүйлийн 30.1.2-т заасан бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж, тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс (радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч, радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч) эзэмшлийн мэдээллийг хүлээн авч, жил бүрийн 12 дугаар сарын 31-ний байдлаар хүлээн авч, нэгтгэн 1-р улиралд багтаан олон нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн 2022 оны мэдээллийг тус хорооны цахим хуудас <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=246> -аас дэлгэрэнгүй танилцах боломжтой.

Үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн эзэмшлийн талаарх мэдээллийг нэгтгэж үзэхэд өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд давхар радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 11 этгээд байгаагаас 2 нь Улаанбаатар хотын буюу Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй, 8 нь аймагт үйлчилгээ эрхлэх хүрээтэй байна. Харин Улаанбаатар хотын буюу Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй 1 этгээд нь өөрийн охин компани дээр радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Улаанбаатар хотын буюу Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 этгээд давхар арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх 3 тусгай зөвшөөрөлтэй эзэмшиж байгаа бол 4 этгээд нь өөрийн охин, хараат, зэргэлдээ компани дээр нийт 5 арилжааны телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Улаанбаатар хотын буюу Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 этгээд нь арилжааны

³⁸ Эрхлэх шинэ жаргалант ХХК-ийн хувьцаа эзэмшилд өөрчлөлт орсон

³⁹ 2022 оны 56-р тогтоол тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулах тухай – Өвөр даваат ХХК-ийн хамрах хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг нэмсэн

⁴⁰ 2022 оны 3-р тогтоол тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай – Скаймедиа групп ХХК-с Тэргүүн медиа ХХК

⁴¹ 2023 оны 9-р тогтоол тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай – Билэгт дөлгөөн ХХК-с Дижитал радио ХХК

⁴² Хэмнэлт долгион медиа групп ХХК-с үйлчилгээний нэрийг Метролоунж-с Хэмнэл радио болгосон

телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5 этгээдтэй нэг компанийн охин компаниуд буюу нэг компанийн нэгдлийн оролцогчид байна.

Компанийн нэгдэл гэж үзэх бололцоотой 3 бүтэц байгаагаас хамгийн том нь 7 тусгай зөвшөөрөл эзэмшиж (Улаанбаатар хотын буюу Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевиз 2, арилжааны 5 телевиз) байх ба үүний 6 нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 6 зэргэлдээ компани байгаа бол 1 нь компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан нэгтэй гэдэг утгаараа нэгдмэл сонирхолтой, хамаарал бүхий гэж тооцогдох боломжтой. Түүнчлэн эдгээр 7 хуулийн этгээдийн 6 нь нэг эцсийн өмчлөгчтэй байна.

Бусад компанийн нэгдэл гэж үзэх боломжтой тохиолдлуудын хувьд хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг нэг хувьцаа эзэмшигчтэй буюу хувьцаа эзэмшигчээрээ холбогдсон 1 бүтэц (өргөн нэвтрүүлгийн 1, арилжааны 1 телевиз), хувьцааг нь нэг этгээд дангаараа эзэмшдэг, эцсийн өмчлөгч нэгтэй, компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой, нэгдмэл сонирхолтой, хамаарал бүхий гэж тооцогдох боломж бүхий 1 бүтэц (өргөн нэвтрүүлгийн 1, арилжааны 2 телевиз) байна.

Улаанбаатар хотын буюу Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй өргөн нэвтрүүлгийн 6 телевиз тус бүр нэг арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна. Арилжааны телевизийн тусгай зөвшөөрөл 2 болон түүнээс дээш тоогоор эзэмшдэг 7 этгээд байгаа ба үүний 5 нь Улаанбаатар хотын буюу Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевиз тус бүр 2-5, нийт 11 арилжааны телевизийн тусгай зөвшөөрлийг шууд болон охин, зэргэлдээ компаниар дамжуулан эзэмшиж байна. Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх 5 тусгай зөвшөөрөл 1 этгээд дээр байгаа бол арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 этгээдийг эдгээр компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан болон эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн нэг хүн байгааг харгалзан нэгдмэл сонирхолтой, хамаарал бүхий гэж тооцогдох боломжтой.

Төлбөртэй телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч 5 этгээд байгаа ба тэдгээр нь нийт 16, тус бүр 1-5 тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Эдгээр үйлчилгээ эрхлэгчдийн телевизийн хөтөлбөр нь тус тусдаа зөвхөн нэг олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээгээр дамжуулагддаг байх ба олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдтэй эзэмшлийн хувьд нэг толгой компани болон охин компанийн харилцаатай 1 этгээд байгаа бол нэг толгой компанийн хараат болон охин компанийн харилцаатай 2 этгээд байна. Бусад 2 этгээдийн хамаарлыг шууд тодорхойлж гаргах бололцоогүй боловч цаашид эзэмшил, өмчлөлийн мэдээллийн нарийвчлан авч, гаргаж, судалгаа хийснээр хамаарлыг тодорхойлох боломжтой юм.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 этгээд нэг толгой компанийн охин компани байгаа бөгөөд олон суваг дамжуулах үйлчилгээний 2 өөр технологи ашиглаж үйлчилгээ эрхэлдэг бол мөн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 этгээд нэг толгой компанийн хараат болон охин компани байгаа ба олон суваг дамжуулах үйлчилгээний 2 өөр технологи ашиглаж үйлчилгээ эрхэлж байна.



IV. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ, ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, өрсөлдөөний нөхцөл байдлыг судлахдаа 2021, 2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн статистик, тоон мэдээлэлд анализ хийсэн бөгөөд Монгол Улсын хүн ам, өрхийн тоо, нягтралыг судлахдаа 2019-2021 оны Үндсэн статистикийн хорооноос гаргасан хүн ам, өрхийн тоо, хүн амын нягтралын тоо мэдээлэлд үндэслэсэн болно.

Нэг. Монгол Улс, Улаанбаатар хот, орон нутгийн хүн ам, өрхийн тоо, нягтралын байдал:

Үндэсний Статистикийн хорооны 2021 оны судалгаагаар Монгол Улсын нийт хүн ам 3,312,275, өрхийн тоо 920,165 байгаагаас Улаанбаатар хотод хүн ам 1,539,252, өрх 412,527, орон нутагт хүн ам 1,773,023, өрх 507,638 байна. Үндэсний Статистикийн хорооны 2020 оны судалгаатай харьцуулахад хүн ам өрхийн тоо 2021 онд Улаанбаатар хотод буурсан, орон нутагт өссөн үзүүлэлттэй байна. Хүн амын нягтралын түвшин 2021 онд Монгол Улсын хэмжээнд 2.2, баруун бүсийн хэмжээнд 1, хангайн бүс 1.6, төвийн бүс 1.1, зүүн бүс 0.8 байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 348.8 байна. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.1212.mn/mn> сайтаас үзэх боломжтой.

Хоёр. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо:

Харилцаа холбооны зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 240 байна. Үүнээс:

- радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч 2;
- олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч 30 байгаагаас Улаанбаатар хотод 13, орон нутагт 17;
- арилжааны (кабелийн сувгийн) телевизийн үйлчилгээ эрхлэгч 58 байгаагаас Улаанбаатар хотод 55, орон нутагт 3;
- өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч 65 байгаагаас Улаанбаатар хотод 18, орон нутагт 47;
- радиогийн (арилжааны радиогийн) үйлчилгээ эрхлэгч 59 байгаагаас Улаанбаатар хотод 33, орон нутагт 26;
- олон нийтийн телевиз 5, олон нийтийн радио 4;
- төлбөртэй телевиз 17 тус тус байна.

Гурав. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдал:

Телевизийн зах зээлийн хэмжээ 2021 оны статистик тайлан мэдээгээр 69.7 тэрбум төгрөг байсан бол 2022 оны мэдээгээр 77.2 тэрбум төгрөг болж өссөн. Үүнээс 2021 онд өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээл 44.6 тэрбум төгрөг буюу 64%, арилжааны телевизийн зах зээл 25.1 тэрбум төгрөг буюу 36% эзэлж байсан бол 2022 онд өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээл 55.3 тэрбум төгрөг буюу 72%, арилжааны телевизийн зах зээл 21.9 тэрбум төгрөг буюу 28%

тус тус эзэлж байна. Арилжааны телевизийн 2022 оны орлого анх удаа зарлага нөхөх хэмжээнд буюу орлого зарлагаас давсан үзүүлэлттэй гарсан байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн орлогын 2020 онд 93.9%, 2021 онд 95.3%, 2022 онд 97%-ийг Улаанбаатар хотын бөгөөд МУ-д хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, үлдсэн хувийг орон нутгийн 47 телевиз бүрдүүлж байна. Арилжааны телевизийн зах зээлийн орлогын 2020 онд 97.6%, 2021 онд 99.7%, 2022 онд 99.6%-ийг Улаанбаатар хотын (МУ-д хамрах хүрээтэй 39) арилжааны 55 телевиз, үлдсэн хувийг орон нутгийн 3 арилжааны телевиз бүрдүүлж тус тус байна.

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлд топ-3 телевизийн эзлэх хувь 2021 онд 48%, зах зээлийн 3 хүртэл хувийг эзэлдэг 7 телевизийн зах зээлд эзлэх хувь нийлбэр дүнгээр 10%-тай, бусад 7 телевиз 5-8%-ийг тус бүр эзэлдэг байсан бол 2022 оны дүнгээр топ-3 телевизийн эзлэх хувь 41% болж буурсан, зах зээлийн 3 хүртэл хувийг эзэлдэг 7 телевизийн зах зээлд эзлэх хувь нийлбэр дүнгээр 18%-тай болж өссөн, бусад 7 телевиз 5-7%-ийг тогтвортой бүрдүүлж байна. Зах зээл дэх төвлөрлийн түвшин (*concentration ratio*⁴³, *төвлөрлийн түвшин, цаашид CR гэх*) 2020 онд CR 64%, өрсөлдөөний түвшин (*Herfindahl–Hirschman index*⁴⁴, *өрсөлдөөний түвшин, цаашид HHI гэх*) 2020 онд HHI 1116-тай буюу төвлөрлийн түвшин дунд, 2021 онд CR 56%, HHI 1093, 2022 онд CR 43%, HHI 949-тай төвлөрлийн түвшин бага, зах зээлд хангалттай тооны өрсөлдөгчтэй бөгөөд төвлөрөл байхгүй гэсэн үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн зардал 2020 онд 30,9 тэрбум төгрөг, 2021 онд 40,1 тэрбум төгрөг, 2022 онд 43,9 тэрбум төгрөг тус тус байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 2022 онд нийт 7,4 тэрбум төгрөг байгаа ба үүний 6,2 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүд, 1,2 тэрбум төгрөгийг орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизүүд дотоодын зээл, дотоодын хандив, тусламж болон өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

Арилжааны телевизийн зах зээлд топ-4 телевизийн эзлэх хувь 2021 онд 71% (топ-3 телевиз 60%), зах зээлийн 4-7%-ийг тус бүр эзэлдэг 3 телевиз, бусад 29 телевиз нийлбэр дүнгээр зах зээлийн 15%-ийг эзэлж байсан бол 2022 оны дүнгээр топ-3 телевизийн эзлэх хувь 68% болж өссөн, зах зээлийн 4-8%-ийг тус бүр эзэлдэг 3 телевиз, бусад 21 телевиз нийлбэр дүнгээр зах зээлийн 15%-ийг эзэлж байна. Статистик тайлан ирүүлсэн арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2020 онд 28, 2021 онд 36, 2022 онд 29 үйлчилгээ эрхлэгч тус тус байна. Зах зээл дэх төвлөрлийн түвшин 2020 онд CR 84%, HHI 1864 -тай төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал, 2021 онд CR 76%, HHI 1498-тай төвлөрлийн түвшин дундаж, дунд зэргийн төвлөрөлтэй, 2022 онд CR 83%, HHI 1929-тай төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал гэсэн

⁴³ Төвлөрлийн харьцааны индекс нь 1-ээс 100 хувийн утга авах бөгөөд үүгээр тухайн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний нөхцөл байдлыг тодорхойлно. Өрсөлдөөний зохицуулалтын практикт ихэнхдээ зах зээл дэх 3, 4, эсвэл 5 томоохон үйлчилгээ эрхлэгчийн төвлөрлийг тодорхойлж үздэг ба хэрэв индексийн утга 80-100 бол төвлөрлийн түвшин өндөр, 50-80 бол төвлөрлийн түвшин дундаж, 0-50 бол төвлөрлийн түвшин бага гэж үзнэ.

⁴⁴ Энэхүү индекс нэгтэй тэнцүү байх нөхцөлд тухайн зах зээлд зөвхөн нэг үйлчилгээ эрхлэгч (монопол) байна. Хэрэв индексийн утга $XXI < 1000$ бол тухайн зах зээлийг хангалттай тооны өрсөлдөгчтэй төвлөрөл байхгүй гэж үзнэ. $1000 < XXI < 1800$ бол тухайн зах зээлийг дунд зэргийн төвлөрөлтэй гэж үзнэ. $XXI > 1800$ бол тухайн зах зээлд төвлөрлийн түвшин өндөр буюу өрсөлдөөн хязгаарлагдмал гэж үзнэ.

үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотын арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн зардал 2020 онд 23,9 тэрбум төгрөг, 2021 онд 25,1 тэрбум төгрөг, 2022 онд 19,5 тэрбум төгрөг тус тус байна. Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 2022 онд нийт 4,6 тэрбум төгрөг байгаа ба дотоодын зээл, өөрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн хэрэглэгчийн тоон судалгааны хувьд 2021 онд нийт 808,463 идэвхтэй хэрэглэгч бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 456,691, орон нутагт 351,772 байсан бол 2022 онд нийт 760,028 идэвхтэй хэрэглэгч бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 424,925, орон нутагт 335,103 хэрэглэгч байна. Хэрэглэгчийн тооны судалгааг телевизийн олон суваг дамжуулж байгаа технологийн төрөл, үйлчилгээ эрхлэгч, үйлчилгээ эрхлэх хүрээгээр гаргасан. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн статистик тайлан мэдээний ирцийг авч үзэхэд 2021 онд 31, 2022 онд 30 үйлчилгээ эрхлэгч статистик тайлан мэдээ ирүүлсэн байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлийн хэмжээ 2021 оны статистик тайлан мэдээгээр 281,1 тэрбум төгрөг, 2022 онд 323,8 тэрбум төгрөг болж өссөн. *(Жич: Үүнд интернэт протоколд суурилсан үйлчилгээ эрхлэгчийн нийт орлогыг авч үзсэн болно.)* 2022 онд орлого 2021 онтой харьцуулахад 15%-р өссөн бөгөөд интернэт протоколд суурилсан үйлчилгээний орлого 22%-р өссөн нь энэхүү өсөлтөд голлож нөлөөлсөн байна. Хиймэл дагуулын үйлчилгээний орлого 4%, утастай, утасгүй сүлжээний орлого 10%-р тус тус буурсан үзүүлэлттэй байна. Зардал 2022 онд 218,7 тэрбум төгрөг байгаа ба өмнөх онтой харьцуулахад 13%-р өссөн. Хөрөнгө оруулалт 2021 онд 36,1 тэрбум төгрөг, 2022 онд 25,9 тэрбум төгрөг байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого 2021 онд 40 тэрбум төгрөг, 2022 онд 48,8 тэрбум төгрөг, 2021 онтой харьцуулахад 22%-р өссөн байна. Нэгж хэрэглэгчээс олох орлого 2021 онд дунджаар 28,978 төгрөг байсан нь 2022 онд өсөж дунджаар 35,509 төгрөг болсон байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний Улаанбаатар хотын зах зээлийн хувьд 2021 онд 456,691 хэрэглэгч, 2022 онд 424,925 хэрэглэгч идэвхтэй байгаа бөгөөд үүний 93% нь Улаанбаатар хотод, үлдсэн 7 хувь нь алслагдсан 3 дүүрэгт харьяалагдаж байна. Зах зээлийн нэвтрэлт нийслэлийн хэмжээнд дунджаар 102%-тай, Улаанбаатар хотод 110% байна. Зах зээл дэх төвлөрлийн түвшин 2021 онд CR 86%, ННН 2700-тай төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал, 2022 онд CR 94%, ННН 3644 төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал байдалтай байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 2022 онд нийт 25,9 тэрбум төгрөг байгаа ба үүний 23,1 тэрбум төгрөгийг интернэт протоколд суурилсан 2 үйлчилгээ эрхлэгч, 1,5 тэрбум төгрөгийг хиймэл дагуулын үйлчилгээ эрхлэгч, үлдсэн 1,3 тэрбум төгрөгийг утастай, утасгүй сүлжээний 5 үйлчилгээ эрхлэгч тус бүр өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

Радиогийн зах зээлийн хэмжээ 2020 онд 1,5 тэрбум төгрөг, 2021 онд 2,2 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 3,3 тэрбум төгрөг болж өссөн буюу сүүлийн 3 жилийн судалгаагаар өссөн үзүүлэлттэй байна. Нийт орлогын 91%-ийг Улаанбаатар хотын радиогийн үйлчилгээ эрхлэгчид бүрдүүлж байна. Улаанбаатар хотын нийт зах зээлийн 67%-ийг нэг этгээд дангаараа бүрдүүлж байна. Радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн зардал 2020 онд 1,9 тэрбум төгрөг, 2021 онд 1,6 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 1,7 тэрбум төгрөг байна. Зах

зээл дэх төвлөрлийн түвшин 2021 онд CR 90%, ННН 4719-тай төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал, 2022 онд CR 91%, ННН 4674 төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал байдалтай байна. Салбарт оруулсан хөрөнгө оруулалт 605 сая төгрөг байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос зарладаг хагас жил болон жилийн эцсийн салбарын үндсэн үзүүлэлт, статистик дата мэдээллийн дэлгэрэнгүйг тус хорооны <https://www.crc.gov.mn/list/zah-zeel-rs-ld-n/mn?show=45> хуудаснаас он тус бүрээр дэлгэрүүлэн үзэх боломжтой ба салбарын 2022 оны жилийн эцсийн үндсэн үзүүлэлт, дата мэдээллийг <https://statistic.crc.gov.mn/#/infograph/4162> -с татан авч, танилцана уу.

Дөрөв. Эрэлт, хэрэгцээ:

Харилцаа холбооны зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоохоор хуульчилсан бөгөөд тухайн үйлчилгээг эрхлэх эрэлт, хэрэгцээ байгаа эсийг тодорхойлох зорилгоор судалгааны асуулга буюу мэдээлэл ирүүлэх маягт гаргаж өөрийн цахим хуудас <https://www.crc.gov.mn/pages/show/rg-n-nevtr-lgijn-jlchilgee-erhlehtusqaj-z-vsh-r-l> -нд байршуулж сонирхогч талуудаас мэдээлэл хүлээн авч ажиллаж байна.

Энэ дагуу 2020 онд ирсэн судалгааг үндэслэн 2020 оны 91 тоот тогтоолоор, 2021 онд ирүүлсэн судалгааг үндэслэн 2021 оны 71 тоот тогтоолоор тусгай зөвшөөрлийн тоог тус тус баталж байсан бөгөөд 2021 оны тоо тогтоох судалгаа, дүгнэлтээр гарсан саналын дагуу нэр бүхий аймагт үйлчилгээ эрхлэх судалгааг дахин авч үзэж, мөн 2022, 2023 онд тус хороонд ирүүлсэн сонирхогч этгээдийн судалгаа, мэдээллийг нэгтгэж 2023 онд тусгай зөвшөөрөл олгох тоо тогтооход үндэслэл болгон авч үзсэн.

Ирүүлсэн судалгааг нэгтгэн үзвэл арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх 2 санал, үүний 1 нь Улаанбаатар хотод, 1 нь орон нутагт, орон нутагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх 2 санал, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх 3 санал, үүний 2 нь орон нутагт, 1 нь интернэтээр дамжуулан олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх хүсэлт, орон нутагт радиогийн үйлчилгээ эрхлэх 2 санал, нийт 9 санал байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн тоог гаргаж, тухайн орон нутагт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй орон нутгийн үйлчилгээ эрхлэгч байхгүй, мөн тухайн орон нутагтаа үйлчилгээ зөвхөн нэг телевизийн тусгай зөвшөөрөлтэй буюу үйлчилгээ эрхлэгчтэй аймгийн судалгааг гаргасан ба нийт 2 аймагт телевиз, 8 аймагт радио, 9 аймагт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч байхгүй байгаа бол нэг телевизтэй 6 аймаг байна.

Тус хорооны 2020 оны 91 тоот, 2021 оны 71 тоот тогтоолоор 2021, 2022 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоог тус тус тогтоосон байх ба 2021 онд 8 аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх 11 квот буюу тоо тогтоох санал оруулж, батлагдсанаас 6 аймагт сонгон шалгаруулалтын санал ирж, 6 этгээдэд өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. 2021 онд 12 аймагт радиогийн үйлчилгээ эрхлэх 12 квот, 2022 онд 3 аймагт радиогийн үйлчилгээ эрхлэх 3 квот



буюу тоо тогтоох санал оруулж, батлагдсанаас 2021 онд 2 аймагт сонгон шалгаруулалтын санал ирж, 2 этгээдэд, 2022 онд 2 аймагт сонгон шалгаруулалтын санал ирж, 2 этгээдэд, нийт 4 аймагт 4 этгээдэд радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Олон суваг дамжуулах үйлчилгээний төрөлд 2020 онд тусгай зөвшөөрөл олгох 1 квот буюу тоо батлагдаж, 2021 онд сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгосон.

V. НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОО ТОГТООХОД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ХАРГАЛЗАН ҮЗСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ШИЙДВЭР

Нэг. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтооход баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлт:

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрлийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйл, тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9 дэх заалтаар тус тус тогтоосон.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлнэ.” гэж; 7 дугаар зүйлийн 7.4.2-т “өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэх,” гэж; 7.4.5-д “энэ хуулийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах,” гэж; 30 дугаар зүйлийн 30.1.9-д “өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоох,” гэж; 30.1.10-т “хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих,” гэж тус тус тодорхойлсны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой харилцааг хуульчилсан.

Зөвшөөрлийн тухай хууль батлагдаж 2023 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд 2023 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох журмыг тусгаж, үүнтэй холбоотой Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-ыг тус хорооны 2023 оны 2 тоот тогтоолоор хүчингүй болгосон.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9-д заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгоно.” гэж заасны дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх дараах төрлийн тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулах зарчмыг баримтлан олгодог. Үүнд:

- Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх;
- Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх;

- Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх;
- Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн дээрх төрөлд нээлттэй сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох тоо тогтооход Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9-ийн дагуу өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэхээр заасан бөгөөд судалгааг дараах холбогдох чиглэлд хийж, уг судалгаанд үндэслэн сонгон шалгаруулалт зарлах боломжтой гэж үзсэн үйлчилгээний төрөл, хүрээг тодорхойлж, дүгнэлт гаргасан болно.

1. Монгол Улс, Улаанбаатар хот, орон нутгийн хүн ам, өрхийн тоо, нягтралын судалгаа;
2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо;
3. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгаа;
4. Эрэлт, хэрэгцээ.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн тоо тогтооход холбогдох дээрх судалгаа, мэдээлэлд үндэслэхээс гадна дараах шалгуурыг харгалзан үзсэн. Үүнд:

1. Радио давтамжийн тусгай зөвшөөрөл шаардлагатай тохиолдолд радио давтамжийн төлөвлөлт, нөөц;
2. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасан зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээний сувгийн багтаамж, нөхцөл байдлыг тодорхойлох.

Тухайн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь үйл ажиллагаа эрхлэхэд радио давтамжийн тусгай зөвшөөрөл шаардлагатай тохиолдолд радио давтамжийн төлөвлөлт, нөөцтэй уялдуулж, тухайн үйлчилгээнд ашиглагдах радио давтамжийн зурвас төлөвлөгдсөн эсэх, нөөцтэй эсэх талаар дүгнэлтэд үндэслэдэг бөгөөд холбогдох судалгааг тус хорооны радио давтамжийн зохицуулалт, хяналтын асуудал хариуцсан нэгжээс гаргуулан авч, нийцүүлсэн.

Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээний ашиглалтыг төр хариуцах бөгөөд уг сүлжээнд олон нийтийн радио, телевиз болон өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг үнэ төлбөргүйгээр холбох, дамжуулах хуулийн зохицуулалт хэрэгждэг ба нээлттэй сонгон шалгаруулалтаар өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тоо тогтооход газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн сүлжээ, сувгийн багтаамж, техникийн нөхцөл байдлыг харгалзан авч үзэх шаардлагатай байдаг. Иймээс Радио, телевизийн газрын сүлжээ Улсын төсөвт үйлдвэрийн газраас техникийн нөхцөл байдал, суурилагдсан хүчин чадал, сувгийн багтаамжийн мэдээлэл, судалгааг авч, тоо тогтооход үндэслэл болгов.

Хоёр. Тус хорооноос 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох тухай шийдвэр:



Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6⁴⁵ дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1⁴⁶ дэх хэсэг, мөн зүйлийн 7.4.1⁴⁷, 7.4.2⁴⁸, 7.4.5⁴⁹ дахь заалтууд, 30 дугаар зүйлийн 30.1.9⁵⁰ дэх заалтыг тус тус үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог дараах үйлчилгээний төрөлд тогтоох санал, үнэлэлт, дүгнэлтийг тус хорооны 2023 оны 4-р сарын 21-ний өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэв⁵¹. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх 1 тусгай зөвшөөрөл;
- Дорноговь аймагт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх 1 тусгай зөвшөөрөл;
- Говьсүмбэр, Дундговь, Булган, Говь-Алтай, Дорноговь, Өвөрхангай, Сэлэнгэ аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тус бүр 1, нийт 7 тусгай зөвшөөрөл;
- Хэнтий аймагт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх 1 тусгай зөвшөөрөл;
- Баянхонгор, Булган, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий, Дорноговь, Өвөрхангай (Хархорин сум) аймагт радиогийн үйлчилгээ эрхлэх тус бүр 1, нийт 10 тусгай зөвшөөрлийн тоог тус тус тогтоов.

Сонгон шалгаруулалтыг Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон тус хорооны даргын 2023 оны А/53 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох дотоод үйл ажиллагааны журам”-д заасан хоног, хугацааг баримтлан зохион байгуулах бөгөөд тус хорооны 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2023 оны 2-3-р улиралд багтаан зарлаж, дүнг Хорооны ээлжит хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд 2023 онд багтаан сонгон шалгаруулалтыг дахин зарлахаар төлөвлөж байна.

Цаашид Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т заасан үнэлэлт дүгнэлтийг тус хорооноос жил бүр гаргадаг салбарын жилийн эцсийн үндсэн үзүүлэлт, статистик дата мэдээлэл зарлагдсаны дараа, жил бүрийн 2-р улиралд багтаан гаргаж ажиллах болно.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

⁴⁵ Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл;

⁴⁶ Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлнэ.

⁴⁷ өргөн нэвтрүүлгийн талаар төрөөс баримталж байгаа бодлого, харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн хөгжлийн ирээдүйн чиг хандлага, техник, технологийн дэвшил, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, эрх ашигт нийцүүлэн зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх;

⁴⁸ өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэх;

⁴⁹ энэ хуулийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах;

⁵⁰ өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоох;

⁵¹ ХХЗХ-ны 2023 оны 35 тоот тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай тогтоол